

**АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр

Дорноговь аймаг

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зохион байгуулах ажил	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хэрэгжилт
1	2	3	4	5	6
1.	1. Төрийн албаны хүний нөөцийн удирдлага болон томилгооны ил тод, мэргэшсэн, тогтвортой байдлыг бэхжүүлэх чиглэлээр:	1.1.1.Төрийн байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, төрийн албан хаагчийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.	Ажлын гүйцэтгэлийн хувь	Төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэг сайжирсан байна.	Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн “Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал зэрэглэлийг шинэчлэн батлах тухай” А/157 дугаар тушаал, мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эрхзүйн хэлтсээс 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 1-2-/10647 дугаартай албан бичигтэй танилцаад албан хаагч нарт Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.4, Төрийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлд заасны дагуу сонсох ажиллагааг явуулах асуудлаар урьдчилан мэдэгдэж сонсох ажиллагааг 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр гүйцэтгэсэн. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/157 тушаалаар тус хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг

					29, мөн 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн Б/407 дугаар тушаалаар гэрээт ажилтны 2 орон тоо, нийт 31 орон тоотойгоор баталсан. Үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал зэрэглэлийг шинэчлэн баталсантай холбогдуулан тус хэлтсийн албан хаагчдыг 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс чөлөөлж, 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр тус хэлтсийн албан хаагчдыг томилсон.
		1.1.2.Төрийн захиргааны албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа хангагдсан байна.	“Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар ханган ажилласан. Үүнд: -2025 оны 04 дүгээр сарын 09-11-ний өдрүүдэд улсын бүртгэгч нарыг мэргэшүүлэх нэгдсэн сургалт зохион байгуулсан. -Удирдлагын академийн дунд хугацааны сургалтад Замын-Үүд сумын улсын бүртгэгч,мөн Удирдлагын академийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтанд хамрагдах тухай 2 албан хаагчийн хүсэлтийг Эрхзүйн сургалтын хэлтэст хүргүүлсэн.

					-УБЕГ-ын даргын 2025 оны “Сургалт зохион байгуулах тухай” А/172 дугаар тушаалын дагуу төрийн захиргааны албан тушаалд шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх, дадлагажуулах сургалтанд хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ нь хамрагдсан. -УБЕГ-ын даргын Б/458 дугаар тушаалаар төрийн албан хаагчид шинээр зэрэг дэв олгосон 1, зэрэг дэвийг 8 албан хаагчид ахиулан олгосон. -Хэлтсийн нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 2 удаа хамруулсан. -УБЕГ-ын даргын шийдвэрлэсэн иж бүрэн компьютер-1, зөөврийн 3 компьютер, принтрийг хэлтсийн албан хаагчдад хувиарлан ажилласан. -Хэлтсийн албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон сар бүр унаа, хоолны мөнгө, орон нутгийн нэмэгдэл, төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг үндсэн цалин дээр нэмж олгосон. Улсын бүртгэлийн байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8.15.2-д заасны улсын бүртгэгч нас барахад ар гэрт нь 1 удаагийн
--	--	--	--	--	---

					буцалтгүй мөнгөн тусламж, хэлтсийн албан хаагчдын хуримтлалын сангаас ар гэрт гачигдал тохиолдсон, 6 албан хаагчийн гэр бүлд нь нийт 4,380,000 төгрөгийн тусламж үзүүлсэн байна. Сайншанд хотод үйл ажиллагаа явуулдаг барилгын компаниудын удирдлагуудтай уулзалт хийж Энержи парагон ХХК-ийн 2025 оны 3 дугаар улиралд ашиглалтанд орсон орон сууцнаас 1 албан хаагчид хөнгөлөлттэй үнээр, мөн Гантулга трейд ХХК-ийн Мандах наран хорооллын төрийн албан хаагчийн түрээсийн орон сууцанд 1 албан хаагчийг тус тус хамруулж нийгмийн баталгааг ханган ажилласан.
		1.1.3.Төрийн албаны сул орон тооны талаарх мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэн, чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн албыг бүрдүүлнэ.	Ажлын гүйцэтгэлийн хувь	Мэдээлэл ил тод болсон байна.	Тус хэлтсийн ажлын байрны сул орон тоог нөхөх төрийн албаны тусгай шалгалтыг нээлттэй зарлаж, уг орон тоонд ажиллах хүсэлтэй ирүүлсэн иргэдээс албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан албан хаагчийг УБЕГ-ын даргын тушаалаар томилон ажиллуулдаг. Өнөөдрийн байдлаар тус ажлын байранд сул 3 орон тоо гарсныг УБЕГ-ын Төрийн албаны салбар зөвлөлд хандан бүртгүүлээд байна.

		1.1.4.Төрийн албаны хүнд суртлыг арилгах, төрийн албанд хууль бусаар томилогдох, ах дүү хамаатан садан, хамаарал бүхий этгээдүүдэд давуу байдлыг бий болгохтой хатуу тэмцэнэ.	Ажлын гүйцэтгэлийн хувь	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Тус хэлтэст хууль бусаар томилогдсон албан хаагч болон ах, дүү хамаатан садан, хамаарал бүхий этгээд байхгүй бөгөөд энэ талаар албан хаагчдад тодорхой сануулж давуу байдал үүсгэхгүй байх дээр мэдээлэл өгсөн.
2.	1 .Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянах чиглэлээр:	2.1.1.Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулах, зөрчилтэй этгээдийг томилсон албан тушаалтанд харицулага тооцон ажиллана.	Хянуулсан мэдүүлгийн тоо	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авилгатай тэмцэх газарт хянуулан УБЕГ-ын даргын тушаалаар албан тушаалд томилдог.
3.	1 .Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэн, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн бодит оролцоо, үр дүнтэй хяналтыг бэхжүүлэх чиглэлээр:	3.1.1.Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх болон хэрэгжилтийг үнэлэхэд иргэн, иргэний нийгмийн байгууллагуудын бодит оролцоог хангаж, иргэнд ээлтэй бодлого, шийдвэр гаргах нөхцөлийг ханган ажиллана. 3.1.2.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх “Шүгэл үлээх”, “Шүүр”, “Шилэн” гэх мэт олон нийтийн хяналтын механизмыг бий болгож, Авлигыг мэдээлсэн иргэдийг	Ажлын гүйцэтгэлийн хувь	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Хэлтсийн дарга 2025 оны 04 дүгээр сарын 10-нд зохион байгуулсан “Бүртгэлийн нэгдсэн сургалт”-аар нийт албан хаагчдад төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, ил тод, хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх, төрийн албан хаагчийн ёсзүй, авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллах чиглэлээр зөвлөмж өгч ажилласан. Авилгын эсрэг үйл ажиллагааг мэдээлэлн сурталчилах зорилгоор мэдээллийн самбарыг тогтмол шинэчлэн ажиллаж байна. “Авилгын эсрэг хамтдаа” самбарын дэргэд санал хүсэлтийн хайрцаг байршуулсан.

		дэмжин орон нутгийн түвшинд асуудлыг шийдвэрлэнэ. 3.1.3.Авлигыг мэдээлэх тогтолцоог хялбаршуулах, мэдээлэгчийн эрхийг хамгаалах, таслан зогсоох арга хэмжээ авна. 3.1.4.Олон нийтийн хяналтыг бий болгох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор авлигыг мэдээлэх тусгай самбарыг бэлтгэн аймаг, сумдын ЗДТГ-ын гадна талд болон төв зам дагуу байршуулж иргэд, олон нийтэд сурталчилна.			Тус хэлтсийн үйлчилгээний зааланд байршуулсан LED дэлгэцээр АТГ-аас гаргасан авлигын эсрэг цахим мэдээллийг иргэдэд тогтмол хүргэн ажиллаж байна. Харааны бэрхшээлтэй иргэнд зориулан барел үсгээр Иргэн та дараах тохиолдолд АТГ-т хандах боломжтой, АТГ-ын мэдээлэл хүлээн авах 110 дугаар зэргийн мэдээллийг агуулсан хуудсыг байршуулсан. Мөн үйлчилгээний заалны шилэн хаалга болон “Цаг хэмнэсэн-цахим булан”-гийн шилэн хаалганд авлигыг мэдээллэх 110 дугаарыг байршуулан иргэд, үйлчлүүлэгчийг мэдээллээр ханган ажиллаж байна
4.	1 .Авлигын эрсдэлийг тодорхойлж, хариу арга хэмжээ авар чиглэлээр	4.1.1.Авлигын эрсдлийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллана. 4.2.2.Төрийн аудитын байгууллагатай хамтран ажиллаж, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлнэ. 4.4.3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавин, тендерийн	Ажлын гүйцэтгэлийн хувь	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Тайлант хугацаанд АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, мэдэгдэл ирээгүй байна. Иргэдээс ажилтан, албан хаагчдад Авлигатай холбогдуулан гаргасан гомдол байхгүй байна. Тус хэлтэс нь Төрийн аудитын газраас 2024 оны санхүүгийн тайлангийн аудитыг түүврийн аргаар хийсэн бөгөөд зөрчил гараагүй. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавин сар бүр мэдээллийг шилэн дансанд байршуулан ажиллаж байна.

		үнэлгээний хорооны гишүүдэд сургалт зохион байгуулна.			
5.	1.Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулах чиглэлээр:	5.1.1.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд соёл урлаг, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ.	Ажлын гүйцэтгэлийн хувь	Төрийн албан хаагчид болон иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газраас “Мөрдөгчийн мэдэгдэл хүргүүлэх тухай” 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 3/8699 дугаар албан бичиг ирүүлсний дагуу хэлтсийн албан хаагч нарт танхимаар, сумдын улсын бүртгэгч нарт цахимаар (zoom) хурал хийж Авилгатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 90 дугаартай мөрдөгчийн мэдэгдлийг танилцуулж, хяналтын улсын байцаагч, улсын ахлах бүртгэгч нарт Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулахыг үүрэг болгосон. Мөн иргэний мэдээллийн цахим системд тухайн иргэнийг өөрийн биеэр хүрэлцэн ирээгүй тохиолдолд аливаа төрлийн бүртгэл хийхгүй байх, зөвхөн хурууны хээ уншуулж улсын бүртгэл хөтлөхийг улсын бүртгэгч нарт анхааруулж, сануулга өгч, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр, сурталчилгааны материал тараах арга хэмжээ авч ажиллахыг улсын ахлах бүртгэгч нарт үүрэг, чиглэл өгч ажиллаласан. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах ажлын хүрээнд

					“АВИЛГА, АШИГ СОНИРХОЛГҮЙ ХАМТ ОЛОН” шторкыг бэлтгэн хэлтсийн фэйж хуудас болон цахим хуудсанд байршуулан олон нийтийн сувгаар мэдээлсэн Мөн өрөө бүрт Авлигатай тэмцэх газраас эрхлэн гаргасан “Нэгдье” зурагт хуудсыг байршуулж урьдчилан сэргийлэх сурталчилгаа, соён гэгээрүүлэх арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан. Мөн дараах зурагт хуудсыг үйлчилгээний заал болон мэдээллийн самбарт байршуулсан. Үүнд: - “Иргэн та бүртгэлийн үйлчилгээний хураамжийг зөвхөн банк болон Гэрэгэ киоск машинд тушаах”, - “Манай үйлчилгээнд яаралтай бүртгэлийн хураамж байхгүй болохыг танд мэдэгдэж байна”, - Бид авилга авахгүй, та авилга өгөх хэрэггүй, бид танд үйлчлэх үүрэгтэй” - “Иргэн танд ёсзүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл байвал бичгээр хандана уу” - Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулж барел үсгээр “Иргэн та дараах тохиолдолд АТГ-т хандах боломжтой” АТГ-ын мэдээлэл хүлээн авах
--	--	--	--	--	--

					110 дугаар зэргийн мэдээллийг агуулсан хуудсыг тус тус байршуулсан.
		5.2.2.Төрийн албан хаагч болон удирдах албан тушаалтанд авлигын эсрэг сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.			“Бүртгэлийн ажилтны нэгдсэн сургалт”-д Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Эрдэнэбаярыг урьж Авилгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж хэлтсийн нийт 27 алба хаагчид хамрагдсан. Мөн 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурорын газар хамтран “Авлигаас урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдвээр цахимаар зохион байгуулсан сургалтанд хэлтсийн дарга болон хяналтын улсын байцаагч, улсын ахлах бүртгэгч нар хамрагдсан. Хэлтсийн хамт хурлыг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зарлаж албан хаагч нарт “Авлигаас урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх” талаар мэдээлэл өгч ажилласан.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС